



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 23

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар 77.3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.2 дахь хэсгийг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Өмнөговь аймгийн ИТХ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 35,500,000 (гучин таван сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэтэй автомашин, тоног төхөөрөмжийг балансын өртгөөр нь Дундговь аймгийн ИТХ-д бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Дундговь аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

480219057